



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 11105

Шивээговь сум

Газар эзэмших эрхийн зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.6, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар “Журам батлах тухай”- тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.4, 8.1.9, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Манлайн Жаргал нь Шивээговь сумын 2 дугаар баг, Хаялга нуурын урд талд байрлах “Загас үржүүлэг”-ийн зориулалттай 3 га газрынхаа газар эзэмших эрхийн зориулалтад өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тул газрын зориулалтыг “Аялал жуулчлалын бааз” болгон өөрчилж, үлдсэн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшиж буй газрынхаа орчныг эрүүл, хог хаягдалгүй байлгаж, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, ногоон байгууламжийг бий болгон Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг иргэн (М.Жаргал)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч М.Жаргалтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олgon хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбүд)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/79 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

D:\My Documents\zaxiramj.doc

42124 263